



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/355

Арвайхээр сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.3, Захиргааны ерөнхий хуулийн 38.2.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/116 дугаар захирамжийн нэг дэх хэсэгт заасан Цагдаагийн газарт автомашин авах зардалд 45,000,000 гэснийг Санхүү, хяналт аудитын албанд автомашин авах зардал 53,000,000 (тавин гурван сая) гэж, нийт 78,000,000 гэснийг 86,000,000 (наян зургаан сая) төгрөг гэж тус тус өөрчилсүгэй.

2. Батлагдсан хөрөнгө оруулалтуудын худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газарт даалгасугай.

3. Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0728

D:My Doc. Zahiramj. Zasag darga